*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

# САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ БААТАР ОВОГТОЙ БЯМБАЦОГТЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦМИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэл-тийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| НЭГ.“ГААЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ДЭД БҮТЭЦ, ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 1 | Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны зохион байгуулалт, үр дүн. | Хэрэгжилт гүйцэтгэлээр | | Тайлант хугацаанд төлөвлөсөн худалдан авах ажиллагааг хугацаанд нь ил тод нээлттэй зохион байгуулж, өглөг, авлага үүсгэлгүй ажилласан байна. | • Монгол улсны 2024 оны төсвийн тухай хуулинд Сангийн сайдын багцад тусгагдсан санхүүжилтээс Сангийн яаманд 2024 оны 01 дүгээр сарын 17 -ны өдрийн 01/246, 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 01/1891 дугаартай албан бичиг хүргүүлсний дагуу хилийн боомтын бүтээн байгуулалтын ажил нь дууссан Замын-Үүд боомтын ачаа тээврийн цогцолбор, бүтээн байгуулалтын ажил хийгдэж байгаа Гашуунсухайт боомтын ачаа болон зорчигч тээврийн хэсэгт суурилуулах телехяналтын тоног төхөөрөмжийн төсөв, Алтанбулаг, Боршоо боомтод суурилуулах ариутгалын барилга байгууламж, гаалийн байгууллагад шаардлагатай хяналтын тоног төхөөрөмжийн төсөв, гаалийн газар, хороодод шаардлагатай байгаа мателл илрүүлэгч хаалга, хүний биеийн дулаан мэдрэгч термокамерын | 2024.01.01-2024.12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төсөв, Увс аймаг дахь гаалийн хяналт, бүрдүүлэлтийн барилгын тохижилтын тоног төхөөрөмж худалдан авах санхүүжилтэд Сангийн сайдын 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 11 дугаартай тушаалаар 6,280.8 сая.төгрөг, Гаалийн байгууллагын тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж худалдан авах санхүүжилтэд Сангийн сайдын 2024 оны 06 дүгээр сарын 20-ны өдрийн 121 дугаартай тушаалаар 2,190.0 сая.төгрөг, нийт 8,470.8 сая.төгрөгийн санхүүжилт шийдвэрлэгдэж худалдан авах ажиллагааг холбгодох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан.<br>• Сангийн сайдын 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 11 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан төсвийн хүрээнд худалдан авалт хийгдсэн зорчигчийн ачаа тээш шалгах рентген төхөөрөмж, ариутгалын байгууламж тоног төхөөрөмж, хүний биеийн халуун хэмжигч болон металл мэдрэх тоног төхөөрөмжийн худалдан авах ажиллагааг зохион байгуулах ГЕГ-ын даргын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн А/130, А/131, А/132, А/358 дугаартай тушаал батлагдсан. ГЕГ-ын даргын А/130 дугаартай тушаалаар батлагдсан үнэлгээний хорооны нарийн бичгээр ажиллаж “Хүний биеийн халуун хэмжигч, металл мэдрэх зориулалттай гаалийн хяналт шалгалтын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/” нийлүүлэх тендерийг 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр нээлттэй тендер шалгаруулалтын аргаар цахимаар зарлаж тендерт материалаа ирүүлсэн компанийн материалд үнэлгээг хийж, “Нанопланет” ХХК-ийг шалгаруулж, 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдөр гэрээг байгуулан тоног төхөөрөмжийг 2024 оны 08 сард ашиглалтад | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хүлээн авч, гүйцэтгэлд шаардлагатай баримт бичгийн бүрдлийг Сангийн яаманд хүргүүлж, санхүүжилтийг олгосон. ГЕГ-ын даргын А/131 дугаартай тушаалаар батлагдсан үнэлгээний хорооны нарийн бичгээр ажиллаж “Зорчигчийн ачаа тээш шалгах зориулалттай гаалийн хяналт шалгалтын рентген тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/” нийлүүлэх тендерийг 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр нээлттэй тендер шалгаруулалтын аргаар цахимаар зарлаж, тендерт материалаа ирүүлсэн компанийн материалд үнэлгээ хийж, “Масс Теч” ХХК-ийг шалгаран 2024 оны 06 сарын 05-ны өдөр гэрээ байгуулан зорчигчийн ачаа тээш шалгах зориулалттай гаалийн хяналт шалгалтын төхөөрөмжийг 2024 оны 09 сард ашиглалтад хүлээн авч, гүйцэтгэлд шаардлагатай баримт бичгийн бүрдлийг Сангийн яаманд хүргүүлж, санхүүжилтийг олгосон. Ариутгалын байгууламж, тоног төхөөрөмжийг худалдан авах ажилллааг зохион байгуулж 2024 оны 09 сард Боршоо боомтод ажил гүйцэтгэх “Нью фоос” ХХК-тай 2024 оны 09 сарын 15-нд гэрээ байгуулсан. Мөн Алтанбулаг боомтод ажил гүйцэтгэх “Ханхилцаг гол” ХХК-тай 2024 оны 10 сарын 01-нд гэрээ байгуулсан. Ариутгалын барилга байгууламж, тоног төхөөрөмжийн суурилуулалтын ажил хийгдэж байна. Сангийн сайдын 2024 оны 11 дүгээр тушаалаар санхүүжилт нь шийдвэрлэгдсэн санхүүжилтээс ариутгалын барилга байгууламж, тоног төхөөрөмжийн ажлаас бусад ажлууд 100 хувь дуусч, гүйцэтгэгчид санхүүжилт олгогдсон.<br>• Сангийн сайдын 2024 оны 06 дүгээр сарын 120-ны өдрийн 121 дугаартай тушаалын хавсралтаар батлагдсан төсвийн хүрээнд | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | худалдан авалт хийгдэх Гаалийн байгууллагын тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн худалдан авах ажиллагааг зохион байгуулах ГЕГ-ын даргын 2024 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн А/400 дугаартай тушаал батлагдсан. Тус тушаалын хүрээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулж, 6 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, 9 төрлийн тээврийн хэрэгсэл худалдан авахаас 8 тээврийн хэрэгслийг бүрэн хүлээн аваад байна. Увс аймаг дахь Гаалийн газарт ашиглагдах нүүрс тээврийн автомашиныг 12 сарын 15-нд хүлээн авснаар ажил 100 хувь дуусч, Сангийн сайдын 121 дугаартай тушаалаар батлагдсан 2,190.0 сая.төгрөгийн санхүүжилт гүйцэтгэчид 100 хувь олгогдоно.<br>• ГЕГ-ын 2024 оны худалдан авах төлөвлөгөөнд тусгагдсан цөмийн материал, цацраг идэвхт үүсгүүр илрүүлэх зориулалттай цацрагийн хяналтын төхөөрөмжүүдийг шилжүүлэн суурилуулах /Алтанбулаг, Боршоо боомт/ ажил, гаалийн хяналт шалгалтын рентген тоног төхөөрөмжүүдийн засварын ажил (Алтанбулаг боомт)-ын худалдан авах ажлыг зохион байгуулах үнэлгээний хороо ГЕГ-ын даргын А/186, А/187 дугаартай тушаалаар батлагдсан. 2024 оны 06 сард гүйцэтгэгч “Масс Теч” ХХК-тай гэрээ байгуулсан бөгөөд “Цөмийн материал, цацраг идэвхт үүсгүүр илрүүлэх зориулалттай цацрагийн хяналтын төхөөрөмжүүдийг шилжүүлэн суурилуулах /Алтанбулаг, Боршоо боомт/” ажлыг хүлээн авах ажлын хэсэг ГЕГ-ын даргын баталсан 2024 оны 09 дүгээр сарын 19-ны өдрийн А/468 дугаартай тушаалаар байгуулагдаж ажлын хэсэг ажиллан хүлээн авч, санхүүжилтийг 2024 оны 11 сард | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | олгосон. Гаалийн хяналт шалгалтын рентген тоног төхөөрөмжүүдийн засварын ажил (Алтанбулаг боомт)-ыг хүлээн авах ажлын хэсэг ГЕГ-ын даргын баталсан 2024 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн А/544 дугаартай тушаалаар байгуулагдаж ажлын хэсэг ажиллан тоног төхөөрөмжийн ажиллагааг шалган ашиглалтад хүлээн авч, санхүүжилтийг 2024 оны 11 сард олгогдож, ажил 100 хувийн гүйцэтгэлтэй бүрэн дууссан.<br>• ГЕГ-ын 2024 оны худалдан авах төлөвлөгөөнд тусгагдсан Гаалийн мэдээллийн системийн аюулгүй байдлыг хангах техник хэрэгсэл, лиценц худалдан авах ажлыг зохион байгуулах ГЕГ-ын даргын А/250, А/251 дугаартай үнэлгээний хороо байгуулах тухай тушаалыг батлагдсан. Гаалийн мэдээллийн системийн аюулгүй байдлыг хангах техник хэрэгслийн худалдан авах ажиллагааг зохион байгуулж гүйцэтгэгч “Саммит компьютер технологи” ХХК-тай гэрээ байгуулан тоног төхөөрөмжийг 2024 оны 11 сард ашиглалтад хүлээн авсан. Гаалийн мэдээллийн системд ашиглагдах программ хангамжийн лиценз нийлүүлэх гэрээг гүйцэтгэгч “Саммит компьютер технологи” ХХК-тай байгуулан 11 сард хүлээн авч ажлууд 100 хувь дуусаж, санхүүжилтүүдийг олгосон.<br>• ГЕГ-ын 2024 оны худалдан авах төлөвлөгөөнд тусгагдсан “Бага үнэтэй түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс” худалдан авах үнэлгээний хороо ГЕГ-ын даргын А/401 дугаартай тушаалаар батлагдсан үнэлгээний хорооны нарийн бичгээр ажиллаж тендерийг харьцуулалтын аргааг зохион байгуулж, | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шаардлага хангасан “Фленти Трейд” ХХК-тай 2024 оны 08 сард гэрээ байгуулсан.<br>• ГЕГ-ын 2024 оны худалдан авах төлөвлөгөөнд тусгагдсан “Антивурисын программ лиценз” нийлүүлэх үнэлгээний хороо ГЕГ-ын даргын А/615 дугаартай тушаалаар батлагдсан. Тендерийг харьцуулалтын аргаар зохион байгуулагдаж гэрээ байгуулагдахаар хүлээгдэж байна.<br>• Боомтын сэргэлтийн үндэсний хорооны даргын 2024 оны 03 дугаар сарын 19-ны өдрийн А/16 дугаартай тушаалаар байгуулагдсан үнэлгээний хороо 2024.03.22-нд хуралдаж Б17 – Хилийн хяналтын тавилга, Б18 – Алтанбулаг, Боршоо, Сүхбаатар боомтын хаяг, Б19 – Үйлчилгээний заалны тавилга, Б20 – Сэрээт өргөгч, Б21 – КАИС лиценз BI, Б22 – КАИС лиценз Tableu, Б3 – КАИС лиценз ESB, Б23 – Бичигт боомтын худаг худалдан авах тендерийн бичиг баримтыг хэлэлцэж, Азийн хөгжлийн банкны журмаар худалдан авалтуудыг харьцуулалтын аргаар болон шууд гэрээ байгуулах аргаар зохион байгуулсан. Тендерийг 2024 оны 05 дугаар сарын 06-ны өдөр тендерийг нээж материалаа ирүүлсэн аж ауйн нэгжүүдийн материалд үнэлгээ хийж дараах аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулсан. Үүнд:<br>○ Гаалийн ерөнхий газрын КАИС-ийн лиценз нийлүүлэх Б-3, Б-21, Б-22 багцын тендерийг АХБ-ны шууд худалдан авах арга буюу үнийн саналыг Новелсофт ХХК-аас авах ажлыг зохион байгуулж, АХБ-нд хянуулж гэрээ байгуулагдаж хүлээн авсан. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ○ Б17 хил хяналтын байгууллагуудын тавилга, хэрэгсэл нийлүүлэх тендерт Тренд мебель Монголия ХХК-ийн материал шаардлага хангасан гэж үзэж шалгаруулахаар үнэлгээний хорооны шийдвэр гарч, АХБ-нд хянуулж гэрээ байгуулагдаж хүлээн авсан.<br>○ Б18 – Алтанбулаг, Боршоо, Сүхбаатар боомтын хаяг нийлүүлэх тендерт хамгийн бага үнийн санал ирүүлсэн Оргил деко ХХК-ийн материал шаардлага хангасан гэж үзэж шалгаруулахаар үнэлгээний хорооны шийдвэр гарч, АХБ-нд хянуулж гэрээ байгуулагдаж хүлээн авсан.<br>○ Б19 – Үйлчилгээний заалны тавилга нийлүүлэх тендерт Тренд мебель Монголия ХХК-ийн материал шаардлага хангасан гэж үзэж шалгаруулахаар үнэлгээний хорооны шийдвэр гарч, АХБ-нд хянуулж гэрээ байгуулагдаж хүлээн авсан.<br>○ Б20 – 1 ширхэг Сэрээт өргөгч худалдан авах ажлыг зохион байгуулан шаардлага хангасан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулагдаж хүлээн авсан. | | |
| 2 | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт | Төсвийн хэмнэлт, хувиар, Үүссэн өглөг, авлага, төгрөгөөр, Гэрээний | | Өөрийн нэгжийн чиг үүргийн хүрээнд ГЕГ-ын даргын 2024 оны А/190 дүгээр тушаалын хавсралтад заасан бодлогын баримт | Шинэ сэргэлтийн бодлогын нэг дэх хэсэгт заасан Боомтын сэргэлтийн бодлогын 1.1.8 дахь хэсэг:<br>**Гаалийн хяналтын шалгалтын тоног төхөөрөмж:**<br>• ОХУ-ын "ИСБ.А" компанитай 2023 оны 12 дугаар сард байгуулсан гэрээний дагуу Замын-Үүд боомтод суурилуулсан ИСБА загварын | 2024.01.01-2024.12.10 | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | биелэлтийн үнэлгээгээр | | бичгийн хэрэгжилтийг тайлагнан ажилласан байна. | №006 дугаартай хяналтын төхөөрөмжийг 2023 оны 12 сард хүлээн авах комиссоос өгсөн үүрэг даалгаврын шалгаж, 2024 оны 04 дүгээр сарын 19-нд ажлын хэсэг гарын үсэг зурж, ашиглалтад хүлээн авсан. Гэрээний дагуу тус 1 иж бүрдэл №ISBA-006 дугаартай хяналтын төхөөрөмжийн эцсийн гүйцэтгэл болох үнийн дүнгийн 60% буюу 3,213.0 сая.төгрөгийг 2024 оны барьцаа хөрөнгөд байршуулсан санхүүжилтээс 2024 оны 06 дугаар сард гүйцэтгэгчид олгосон.<br>• Хилийн боомтын шинэчлэл, бүтээн байгуулалтын ажилтай уялдуулан гаалийн хяналт, шалгалтын тоног төхөөрөмж суурилуулах ажлыг үргэжлүүлэн ОХУ-ын "ИСБ.А" компанитай байгуулсан гэрээнд 2024 оны 04 дүгээр сарын 11-нд нэмэлт өөрчлөлт оруулан Монгол улсын төсвийн тухай хуулийн дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжих шинээр худалдан авах 2 иж бүрдэл төхөөрөмжийг Гашуунсухайт /импорт/, Замын-Үүд /экспорт/ хилийн боомтод суурилуулахаар гэрээг байгуулсан.<br>• Булган боомтод №ISBA-008 дугаартай 1 иж бүрдэл тоног төхөөрөмжийг 2024 оны 08 дугаар сард ГЕГ-ын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг ажиллан 2024 оны 09 сарын 20-нд ашиглалтад хүлээн авсан. Нэмэлт гэрээний дагуу 2024 оны барьцаа хөрөнгөд байршуулсан санхүүжилтээс Булган боомтын 1 иж бүрдэл төхөөрөмжийн гүйцэтгэл болох үнийн 5,450.0 сая.төгрөгийн санхүүжилтийг 2024 оны 10 сард гүйцэтгэгчид 100 хувь олгосон.<br>• Гашуунсухайт /экспорт/ талд суурилуулж №ISBA-009 дугаартай 1 иж бүрдэл тоног төхөөрөмж нь 2024 оны 09 сард ирсэн тул явцын санхүүжилт болон 2,140.0 сая.төгрөгийг 2024 | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | оны барьцаа хөрөнгөд байршуулсан санхүүжилтээс 2024 оны 10 сард олгосон. Тус төхөөрөмжийг хүлээн авах ГЕГ-ын 2023 оны А/38 дугаартай тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг 2024 оны 11 сарын 28-нд ажиллаж 16 чиглэлийн үүрэг даалгавар өгсөн. Үүрэг даалгаварын биелэлтээр №ISBA-008 дугаартай тоног төхөөрөмжийг ашиглалтад хүлээн авснаар 2024 оны барьцаа хөрөнгөд байршуулсан санхүүжилт бүрэн олгогдож дууслна. МУ-ын Засгийн газрын 2023 оны 12 сарын 28-нд гарсан тогтоолоор 2024 оны барьцаа хөрөнгөд байршуулсан санхүүжилтын хугацаа 2024 оны 10 сарын 30-ны өдрийг хүртэл байсан тул Сангийн яаманд №ISBA-009 дугаартай тоног төхөөрөмжийн гүйцэтгэлтэй холбоотой тайлбарыг 2024 оны 10 сарын 29-нд 01/4454 дугаартай албан бичгээр Сангийн яаманд хүргүүлж шийдвэрлүүлсэн.<br>• Гашуунсухайт /импорт/ талд суурилуулж №ISBA-011 дугаартай 1 иж бүрдэл тоног төхөөрөмжийг 2024 оны 11 дүгээр сарын 22-нд хүлээн авч түр хадгалтад шилжүүлснийг хүлээлцэх акт үйлдэн хүлээн авсан. Гэрээний дагуу явцын санхүүжилт болгох 2,140.0 сая.төгрөгийг 2024 оны төсвийн тухай хуулийн санхүүжилтээс олгохоор болсон.<br>• ОХУ-ын “ИСБ.А” компанитай 2019 оны 10 сард байгуулсан гэрээний дагуу нийт 14 төхөөрөмжөөс МУ-ын төсвийн тухай хуулиар батлагдсан санхүүжилтээр өнөөдрийн байдлаар 7 иж бүрдэл тоног төхөөрөмжийг авахаар гэрээг баталгаажуулаад байна.<br>**Гаалийн салбар лабораториудын тоног төхөөрөмж:** | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | • ХБНГУ-ын Бахманн компанитай 2019 онд байгуулсан дээж авч шинжилгээ хийх зориулалттай тоног төхөөрөмжийн суурилуулалтын ажлын гэрээг сунгах, нэмэлт гэрээ байгуулан Шивээхүрэн боомт, Оюутолгой ХХК, Эрдэнэс алт ресурс ХХК-д тоног төхөөрөмжийг суурилуулан ашиглаж эхлэх талаар гэрээний төслийг бэлтгэн нийлүүлэгч талд 2024 оны 03 сарын 12-нд хүргүүлсэн. Үүний дагуу нэмэлт гэрээг байгуулахаар 2024 оны 06 сард, 07 сард, 09 саруудад удаа дараа албан бичиг хүргүүлсэн боловч тодорхой хариу ирүүлээгүй байна.<br>• Ажлын хэсгийн зүгээс Шивээхүрэн боомтод суурилуулах төхөөрөмжийн зураг төслийг боловсруулан холбогдох байгууллагаас зөвшөөрөл авах ажлыг хийж гүйцэтгэсэн. Мөн Оюутолгойд суурилуулах Texas төхөөрөмжийн зураг төслийг боловсруулах компанитай гэрээ байгуулсан бөгөөд гүйцэтгэгч Бахманн компаниас мэдээлэл авч, зураг төслийн мэргэжлийн компани гүйцэтгэхээр ажиллаж байна.<br>• ГЕГ-ын даргын 2023 оны А/39 дугаартай ажлын хэсгийн зүгээс ХБНГУ-ын Бахманн компанитай 2019 оны 10 сард байгуулсан дээж авч шинжилгээ хийх зориулалттай тоног төхөөрөмжийн суурилуулалтын ажлын гэрээний нөхцөл байдлын талаар ГЕГ-ын газрын удирдлагуудад 2024 оны 11 сарын 07-ны өдөр гэрээний гүйцэтгэл, нөхцөл байдлын талаар танилцуулсан. ГЕГ-ын даргаас тус гэрээний ажлыг эрчимжүүлэх, төслийг амжилттай дуусгах талаар 8 чиглэлийн үүрэг даалгавар өгсөн. Тус үүрэг даалгаврын дагуу зөвхөн гэрээний хугацаанд нэмэлт өөрчлөлт оруулан хүчин | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төгөлдөр гэрээ байгуулах талаар Бахманн компани руу гэрээний сунгалтыг 2024 оны 11 сарын 14-нд 01/4707 дугаартай албан бичгээр хүргүүлсэн боловч гүйцэтгэгч захирал Бахманн нь осолд орж, гэмтэлтэй байгаа тул 2025 оны 01 сарын 15-наас хойш хариу ирүүлэхээр цахим шуудангаар мэдэгдээд байна. | | |
| 3 | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт. | Хэрэгжилт гүйцэтгэлээр | | Нэгжийн чиг үүрэгт хамааралтай болон бусад холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актыг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна. | Цөмийн энергийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь заалт, МУ-ын Засгийн газрын 2022 оны 4 дүгээр тогтоолийн хэрэгжилт:<br>• АНУ-ын Эрчим хүчний яамнаас хэрэгжүүлдэг “Цөмийн материалын хууль бус хөдөлгөөнийг илрүүлэх, саатуулах (NSDD)” төслийн менежер Aldo Melendez болон бусад албаны хүмүүстэй 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдөр цахим уулзалт зохион байгуулж Цөмийн энергийн тухай хууль, Засгийн газрын тогтоолын дагуу хилийн боомтоор нэвтэрч буй бараа, бодис, бүтээгдэхүүнд цөмийн болон цацрагийн хяналт хийхэд шаардлагатай техникийн тусламж авах, хүний нөөцийг бэлтгэх сургалт зохион байгуулах, тоног төхөөрөмжүүдийг шинэчлэх, Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд боомтын шинэчлэлийн ажилтай уялдуулан цацрагийн хяналтын тоног төхөөрөмжийг шинээр нэмэлт гарцуудад суурилуулах зэрэг ажлуудын талаар ярилцсан.<br>• АНУ-ын Эрчим хүчний яам, NSDD төслийн багийнхан Монгол улсад 2024 оны 05 сарын 13-наас ажиллаж ГЕГ-ийн дарга уулзалт зохион байгуулж цөмийн болон цацрагийн үүсгүүрийн хяналтын чиглэлээр хамтран ажиллах дараах асуудлыг ярилцсан. Үүнд:<br>o Боомтын шинэчлэл, Ковид-19 нөхцөл байдалтай уялдуулан цацрагийн хяналтын төхөөрөмжийн хэвийн | 2024.01.01-2024.12.10 | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ажиллагаа доголдсонтой холбогдуулан “Цөмийн материалын хууль бус хөдөлгөөнийг илрүүлэх, саатуулах” төслөөс шинэ төсвийн жилд цацрагийн хяналт төхөөрөмжийн шинэчлэл, завсар үйлчилгээний чиглэлээр хамтран ажиллах саналыг танилцуулсан.<br>o Гаалийн байгууллагын сүлжээнд цацрагийн хяналтын төхөөрөмжийг холбож хяналт шалгалтын мэдээллийг шуурхай авах нөхцөлийг бүрдүүлэхэд шаардлагатай сервер болон тог баригчийг төслөөс худалдан авахаар болсон. NSDD төсөлтэй гэрээ байгуулахаар ажиллаж байна. Гэрээ байгуулагсны дараа буцалтгүй тусламжаар ГЕГ-т ирүүлэхээр болсон.<br>o Гаалийн байгууллагын хяналт шалгалтын чиглэл хариуцсан гаалийн улсын байцаагч нарт 2024 оны 10 сарын сүүлийн 7 хоногт сургалт зохион байгуулахаар тохиролцсон. Сургалтыг 2024 оны 11 сард зохион байгуулсан.<br>o АНУ-ын төсвийн жил 10 сарын 01-ээс дараа жилийн 09 сарын 30 хүртэл байдаг тул 2025 оны төсөвтөө санхүүжилтийг тусган гадаад оронд туршлага судлах, мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулна гэдгээ төслийн менежер мэдэгдсэн.<br>• АНУ-ын Эрчим хүчний яам, NSDD төслийн багийнхантай 2024 оны 05 сард уулзалт хийсний дагуу "Цөмийн материалын | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хууль бус хөдөлгөөнийг илрүүлэх, саатуулах" хөтөлбөр (NSDD)-ийн хүрээнд 2024 оны 11-р сарын 4-өөс 8-ны өдрүүдэд Чингис хаан олон улсын нисэх буудалд "Гаалийн байцаагчдад зориулсан сургалт"-ыг гаалийн газар, хороодын чиглэл хариуцсан 15 гаалийн улсын байцаагчийг сургалтад хамруулж, зохион байгуулалтын ажлыг хийсэн. Төслийн зүгээс сургалтад оролцсон 15 гаалийн улсын байцаагчийн буудал, зам хоног, унааны зардлыг төслөөс хариуцсан бөгөөд мөн ложистикийн асуудлыг шийдвэрлэсэн. "Цөмийн материалын хууль бус хөдөлгөөнийг илрүүлэх, саатуулах" хөтөлбөр (NSDD)-ийн 2 сургагч багш Монгол улсад ирж, цөмийн болон цацрагийн экспорт, импортын хяналтын чиглэлээр гаалийн улсын байцаагч нарт хичээл заасан.<br>• Боомтын бүтээн байгуулалтын ажилтай холбоотойгоор түр хадлгасан байсан цөмийн материал, цацраг идэвхт үүсгүүр илрүүлэх зориулалттай цацрагийн хяналтын төхөөрөмжүүдийг 2024 онд Гашуунсухайт, Алтанбулаг, Боршоо шилжүүлэн суурилуулж ашиглаж эхэлсэн.<br>• ГЕГ-ын 2024 оны 2024 оны 06 сарын 19-ний өдрийн А/346 дугаартай “Комис томилох тухай” тушаалаар ажлын хэсэгт ажиллан "Цөмийн материалын хууль бус хөдөлгөөнийг илрүүлэх, саатуулах" хөтөлбөр (NSDD)-ийн хүрээнд буцалтгүй тусламжаар хүлээлгэн өгсөн багаж хэрэгсэл, сэлбэг хэрэгслийн тооллогыг хийсэн. Тоологын дагуу ГЕГ-ын 2024 оны 2024 оны 06 сарын 25-ний өдрийн А/389 дугаартай тушаалаар гаалийн газар, хороодод 112 нэр төрлийн 2,127.4 сая.төгрөгийн хөрөнгийг хувиарласан. Мөн ГЕГ-ын 2024 оны 2024 оны 06 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сарын 24-ний өдрийн А/382 дугаартай тушаалаар цаашид ашиглах боломжгүй, ашиглалтын шаардлага хангахгүй болсон 90 нэр төрлийн нийт 354.5 сая төгрөгийн үнэ бүхий сэлбэг хэрэгслийг акталсан. | | |
| 4 | Нэгжийн эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал. | Хэрэгжилт гүйцэтгэлээр | | Өөрийн нэгжийн чиг үүргийн хүрээнд эрсдлийн удирдлагыг хэрэгжүүл ажилласан байна. | • Чингис Хаан ОУНБ дахь Гаалийн газрын эвдрэлтэй рентген тоног төхөөрөмжийн засварыг хийлгэх ажлыг Нүктек компанитай тохирч 2024 оны 02 сарын төсвийн хуваарьт төсвийг оруулан шууд худалдан авалт хийж, тоног төхөөрөмжийг хэвийн ажиллагаанд оруулсан.<br>• Булган, Боршоо, Алтанбулаг, Замын-Үүд /төмөр зам/ боомтуудад суурилуулсан цацрагийн хяналтын төхөөрөмжүүдийн хэвийн ажиллагаанд оруулах шаардлагатай 8 төрлийн 29 ширхэг сэлбэг хэрэгслийн тухайн гаалийн газар, хороодоос ирүүлсэн албан бичгийн дагуу олгосон. | 2024.01.01-2024.12.10 | 90 |
| 5 | Үүрэг даалгавар, зөвлөмжийн биелэлт. | Хэрэгжилт гүйцэтгэлээр | | Нэгжийн чиг үүргийн хүрээнд өгөгдсөн үүрэг даалгавар, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна. | • Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухай бүрт нь биелүүллэн ажилласан.<br>• 2025 оны төсвийн төслийн саналыг боловсруулах, танилцуулга /presentation/-ыг бэлтгэсэн.<br>• Гаалийн байгууллагын 2024 оны сургалтын төлөвлөгөөнд цөмийн болон цацрагийн чиглэлийн сургалт зохион байгуулах саналыг ГЕГ-ын Сургалтын төвд хүргүүлж, нэгдсэн төлөвлөгөөнд тусгуулсан.<br>• Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022-2023 онуудад худалдан авсан гаалийн хяналт шалгалтын рентген тоног төхөөрөмжийн мэдээллийг гаргаж ГЕГ-ын Зөрчилтэй тэмцэх газарт дотоод зурвасаар хүргүүлсэн. | 2024.01.01-2024.12.10 | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | • АТГ-ын Мөрдөн байцаах хэлтсийн мөрдөгчийн 49 дүгээр мэдэгдэлд дурдагдсан Гаалийн ерөнхий газрын 2023 оны худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийг гаргаж ГЕГ-ын Захиргааны удирдлагын газарт дотоод зурвасаар хүргүүлсэн.<br>• ОУВС-ийн зөвлөмжийн дагуу Гаалийн ерөнхий газрын даргын баталсан “Хяналт, шалгалтын ажлыг эрчимжүүлэх тусгайлсан төлөвлөгөө”-нд тусгагдсан СХОГ-ын газартай холбоотой гүйцэтгэлийг гаргаж дотоод зурвасаар Хуулийн хэлтэст хүргүүлсэн.<br>• Өөрийн хийж хэрэгжүүлсэн ажлын талаарх 7 хоног бүрийн тайланг гаргаж байсан. | | |
| 6 | Ажлын цаг ашиглалт | Төсвийн хэмнэлт, хувиар, Үүссэн өглөг, авлага, төгрөгөөр, Гэрээний биелэлтийн үнэлгээгээр | | Нэгжийн албан хаагчдын ажлын цаг ашиглалт 100 хувь байна. | • 2024 оны ажлын 251 өдрөөс тайлан хугацаа буюу 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдөр хүртэл буюу 236 өдрөөс 198 өдөр нь ажлын байран дээрээ ажиллаж, албан томилолтоор Сэлэнгэ аймагт 3 удаагийн томилолтоор 7 өдөр, Увс аймагт 6 өдөр, Ховд аймгийн Булган боомтод 7 өдөр, Гашуунсухайт боомтод 4 өдөр, нийт 27 өдөр томилолтоор ажилласан. Мөн Тайланд улсад 6 өдөр, Малайз улсад 5 өдөр, нийт 11 өдөр гадаад улсад сургалтад хамрагдсан байна. Томилолттой холбоотой тайланг тухай бүр нь бичиж удирдлагуудад танилцуулсан. | 2024.01.01-2024.12.10 | 100 |
| 7 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт. | Хэрэгжилт гүйцэтгэлээр | | | • Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжих “Хилийн үр ашгийг нэмэгдүүлэх тогтвортой худалдааны төсөл”-ийн харилцан ойлголцлын санамж бичиг зурах бэлтгэл ажлын танилцуулга 2024 оны 05 сарын 06-аас 10-ны өдрүүдэд Боомтын сэргэлтийн үндэсний хороонд дээр болж, ГЕГ-ын 2024 оны 05 сарын | 2024.01.01-2024.12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 06-ны өдрийн 02/1782 дугаартай албан бичгийн дагуу хэлэлцүүлэгт оролцсон. | | |
| 8 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт. | Хэрэгжилт гүйцэтгэлээр | | Эхний хагас жил: Гаалийн байгууллагын 2024 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, Гаалийн байгууллагын 2024 оны Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө, Гаалийн байгууллагын 2024 оны Архивын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан өөрийн нэгжид хамааралтай ажлуудыг төлөвлөгөөнд заасан хугацаанд бүрэн хэрэгжүүлж ажилласан байна. | • 2023 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг бөглөж баталгаажуулсан.<br>• Гаалийн ерөнхий газрын даргын баталсан "Үнэлгээний хороо байгуулах тухай" тушаалын дагуу 7 үнэлгээний хороонд ажиллахдаа "Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл"-ийг гаргаж ЗУГ-т хүргүүлсэн.<br>• Монгол улсын сайд, Боомтын сэргэлтийн үндэсний хорооны даргын баталсан "Үнэлгээний хороо байгуулах тухай" тушаалын дагуу 1 үнэлгээний хороонд ажиллахдаа "Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл"-ийг гаргасан. | 2024.01.01-2024.12.10 | 100 |

## ХОЁР. МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |

| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Хариуцсан ажлын чиг үүргийн хүрээнд богино хугацааны зорилтот сургалтанд хамрагдах | | | 1 удаагийн сургалтад хамрагдсан байна. /I-IV улирал/ | • Сангийн яамнаас 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр зохион байгуулсан "Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлага ба цахим шинэчлэл" сэдэвт чадавх бэхжүүлэх сургалтад хамрагдсан.<br>• ГЕГ-ын даргын баталсан 2024 оны 07 сарын 19-ны өдрийн А/421 дугаартай тушаалын дагуу Тайланд Улсын Ча-Ам хотноо зохион байгуулагдсан "Цацрагийн үүсгүүр болон цөмийн материалын хууль бус хөдөлгөөнийг илрүүлэх, тодорхойлох систем" сэдэвт сургалтад хамрагдсан.<br>• Сангийн яамнаас 2024 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, үйлчилгээ худалдан авах тухай хууль/Шинэчилсэн найруулга/-ийн хэрэгжилт, худалдан авах ажиллагаанд анхаарах асуудал" сэдэвт сургалтад хамрагдсан.<br>• ГЕГ-ын даргын баталсан 2024 оны 10 сарын 23-ны өдрийн А/567 дугаартай тушаалын дагуу Малайз улсын Куала Лумпур хотод Dell компанийн үйлдвэр дээр мэдээллийн аюулгүй байдлын чиглэлийн тоног төхөөрөмжийн хөгжил дэвшил, хиймэл оюун ухааныг тоног төхөөрөмж дээр хэрхэн ашиглаж байгаа болон гаалийн байгууллагад цаашид шаардлагатай тоног төхөөрөмжийн танилцуулга хийх сургалтад хамрагдсан.<br>• Захиргаа улирдлагын газраас зохион байгуулсан мэдээллийн цагт оролцож, мэдээлэллүүд сонссон. | 2024.01.01-2024.06.10 | 100% |

ТАЙЛАН ГАРГАСАН:

ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ ........................ / Б.БЯМБАЦОГТ/ 2024-12-10

(Албан тушаал) (Нэр, гарын үсэг) (Огноо)

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 6 дугаар хавсралт*

**ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ Б.БЯМБАЦОГТЫН 2024 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС (ГҮЙЦЭТГЭХ АЛБАН ТУШААЛТАН)**

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар
Нэгжийн нэр: Санхүү, хөрөнгө оруулалтын газар

## 1. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| **Зорилт 1. “Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх”-ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт** | | | | | |
| 1. | Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны зохион байгуулалт, үр дүн | 60 | 10 | 70 | |
| 2. | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт | 49.5 | 5 | 54.5 | |
| 3. | Хууль, тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилт | 60 | 10 | 70 | |
| 4. | Нэгжийн эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал | 49.5 | 5 | 54.5 | |
| 5. | Үүрэг даалгаврын биелэлт | 49.5 | 5 | 54.5 | |
| 6. | Ажлын цаг ашиглалт | 60 | 10 | 70 | |
| 7. | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт | 60 | 10 | 70 | |
| 8. | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт. | 60 | 10 | 70 | |
| **Дундаж оноо:** | | | | 64.2 | |

## 2. МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийг хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1. | Хариуцсан ажлын чиг үүргийн хүрээнд богино хугацааны зорилтот сургалтад хамрагдах | 15 | 15 | |
| 2. | Бие даан суралцах | 15 | 15 | |
| **Дундаж оноо:** | | | 15 | |

## 3. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (НЭГЖИЙН ДАРГЫН ҮНЭЛГЭЭ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|

| | 1 | 2 | 3 |
|---|---|---|---|
| 1. | Хандлага, ёс зүй | 7 | |
| 2. | Асуудал шийдвэрлэх | 5 | |
| 3. | Хариуцлагатай байдал | 7 | |
| 4. | Дүн шинжилгээ хийх | 5 | |
| 5. | Ажлын цаг ашиглалт | 7 | |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | | |
| 6 | Мэргэжлийн ур чадвар 1. | 7 | |
| **Дундаж оноо:** | | **6.33** | |

## 4. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (ХАМТ ОЛНЫ ҮНЭЛГЭЭ)

| Д/д | Хандлага, ёс зүй, ур чадвар | Хамт олны үнэлгээ (0-8) |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1. | Хандлага, ёс зүй | 8 |
| 2. | Багаар ажиллах | 8 |
| 3. | Харилцаа | 8 |
| **Дундаж оноо: 8** | | |

## 5. ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно)* | *(70 хүртэлх оноо)* 64.2 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | *(15 хүртэлх оноо)* 15 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Нэгжийн даргын үнэлгээ)* | *(7 хүртэлх оноо)* 6.33 |
| 4. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Хамт олны үнэлгээ)* | *(8 хүртэлх оноо)* 8 |
| 5. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт *(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | *(.......... оноо)* |
| **Нийт оноо =** (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)* )- Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | | **93.53** |

***Үнэлгээ өгсөн:*** ***Нэгжийн дарга***

Санхүү, хөрөнгө оруулалтын газрын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ........................ /Д.Долгорсүрэн/
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

...2024.12.10... *(огноо)*

***Үнэлгээтэй танилцаж,*** ***Төрийн жинхэнэ албан хаагч:***

***зөвшөөрсөн:***
Гаалийн улсын байцаагч ........................ /Б.Бямбацогт/
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2024.12.10 ............................ (огноо

***Үнэлгээг хянасан:***

*Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:*
Дэд даргын албан үүргийг ................................ /Г.Энхтайван/
түр орлон гүйцэтгэгч
*(албан тушаал)* *(гарын үсэг)*

XII/20, 2024 ................................
(огноо)

*Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:*
Хүний нөөцийн хэлтсийн ................................ /Ө.Тэгшээ/
даргын албан үүргийг түр
орлон гүйцэтгэгч
*(албан тушаал)* *(гарын үсэг)*

2024.12.20 ............................ (огноо)

***Үнэлгээг баталгаажуулсан: Төсвийн шууд захирагч***

Гаалийн ерөнхий газрын дарга ................................ /Р.Отгонжаргал/
*(албан тушаал)* *(гарын үсэг)*

2024.12.20 ............................ (огноо)